

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХЭРЭГЖҮҮЛЭГЧЭЭР ТУСГАГДСАН АРГА  
ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ  
/2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/**

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт
				Үндсэн	
<b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>					
4.1.2.4.Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	1	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох	2018-2019	ЗГХЭГ, МХЕГ, ТЕГ	<p><b>1. <u>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүнзгийрүүлэн төлөвшүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:</u></b></p> <p>✓ МХЕГ нь ТХШТХ-ын 2010 оны нэмэлт өөрчлөлтөөр эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр заасан хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Энэ нь Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчдын авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэг арга хэмжээ болж байна. Мэргэжлийн хяналтын байгууллагаас хэзээ, аль байгууллагад, ямар асуудлаар шалгалт хийх нь тодорхой бус байх нь улсын байцаагчийн авлигад өртөх эрсдэлийг бүрдүүлдэг байсан. МХЕГ нь 2018 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг өмнөх оны 12-р сарын 1-нд аль байгууллагад шалгалт хийх, аль байгууллагад зөвлөх, тандан судлах, урьдчилан сэргийлэх 7 хяналтын хэлбэрийн төлөвлөгөөгөө олон нийтэд зарлалаа. Бизнес эрхлэгчид 2018 онд шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах эсэхээ <a href="http://khyanal.gov.mn">khyanal.gov.mn</a> олон нийтэд зориулсан вэбсайтаас орж байгууллагын нэрээр шүүж харах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>✓ Тухайн байгууллагад юу шалгахыг ил тод болгож улсын байцаагч шалгалт хийхдээ аюул, эрсдэлийг тодорхойлох асуултуудаас бүрдсэн хяналтын хуудсаар шалгалт хийдэг. Энэ нь бизнес эрхлэгчид хяналтын хуудсанд заасан асуудлаар урьдчилан бэлтгэснээр улсын байцаагчийг авлигад өртөхөөс сэргийлэх нөгөө талаар үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнийхээ чанарыг сайжруулахад эерэгээр нөлөөлж байна. МХЕГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны А/14 дүгээр тушаалаар хяналтын хуудас боловсруулах аргачлалыг шинэчлэн боловсруулж, хяналтын хуудасны бүтэц, үнэлгээ тооцох аргачлалд өөрчлөлт орууллаа. Мөн 2018 онд хяналт шалгалтад ашиглах 9 хяналтын хуудсыг шинээр, 130 хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж МХЕГ-ын даргын 2018 оны 2 дугаар сарын 7-ны А/15 тушаалаар батлуулан, мөрдүүлсэн. Түүнчлэн шинээр болон шинэчлэн</p>

				<p>боловсруулсан 125 хяналтын хуудасны зөвлөмжийг шинэчлэн боловсруулсныг хянаж, албан бичгээр аймаг, нийслэлийн МХГ-уудад хүргэж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа.</p> <p>✓ Импортлогч, экспортлогчид хилээр бараа бүтээгдэхүүн оруулж ирэхийн өмнө ямар шаардлага хангасан байдгийг мэддэггүй байсан нь хил дээр ажиллаж байгаа улсын байцаагчдыг авлигад өртөх эрсдэлийг бий болгож байсан. Импортлогч, экспортлогчид ямар баримт бичиг бүрдүүлэхийг мэдэхгүйгээс дутуу баримт бичигтэй, шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн хилээр нэвтрүүлэхийн тулд улсын байцаагчийг авлигад өртүүлэх эрсдэлийг бий болгохыг завддаг. Иймд хилээр бараа, бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудастай болгож, 2018 онд шинэчилэн боловсруулж, мэдээллийг ил тод болгосноор зөрчил буурч байна.</p> <p>✓ Улсын байцаагч дурын байгууллагад шалгалт хийхгүй зөвхөн эрсдэлийн үнэлгээгээр эрсдэл өндөр газарт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлдэг болсон.</p> <p>✓ МХЕГ-ын даргын баталсан үйл ажиллагааны хөтөлбөр, удирдамжийн хүрээнд эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг боловсронгуй болгох зорилгоор тандалт судалгааг хэрэгжүүлж, МХЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар сайжруулсан эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийг хэлэлцүүлж 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 09/01 зөвлөлийн хурлын шийдвэрээр Зөвлөлийн хуралд танилцуулсан шалгуур, үзүүлэлтээр 2018 оны эрсдэлийн үнэлгээ хийж, МХБ-ын үйл ажиллагааны шинэчлэл, Монгол Улсын эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан шалгуурыг бодитой, оновчтой боловсруулж, Засгийн газраар шинэчлэн батлуулах ажлыг 2019 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхээр боллоо.</p> <p>✓ Үйлдвэрлэл, үйлчилгээнээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох тандалт судалгааг МХЕГ-ын даргын баталсан үйл ажиллагааны хөтөлбөр, удирдамжийн хүрээнд хэрэгжүүлж, МХЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар судалгааны үр дүнд боловсронгуй болгон сайжруулсан эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийг хэлэлцүүлж 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 09/01 зөвлөлийн хурлын шийдвэр гаргууллаа.</p> <p>✓ Судалгааны ажлын хүрээнд Архангай, Завхан, Хөвсгөл, Говьсүмбэр аймгийн 10 хоол, хүнсний үйлдвэрлэл, худалдааны газар, 1 уурхайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хүнсний аюулгүй байдал хариуцсан зөвлөлтэй хамтран Хүчит шонхор, Барс, Нарантуул худалдааны төвүүдэд, нийслэлийн өлөн гэдэсний 3 үйлдвэрт, 1 барилга, 1 хайрганы ил уурхайд, Дэлхийн банк ОУСК болон АХБ-ны зөвлөхүүдтэй хамт Алтанбулаг боомт, нийслэлийн гүний</p>
--	--	--	--	---

				<p>терминалиудад газар дээр нь очиж үйлдвэрлэл, үйлчилгээ, импорт, экспортын үйл ажиллагаанаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, бодит байдалд эрсдэлийн үнэлгээ хийн, улсын байцаагчдын өмнөх эрсдэлийн үнэлгээтэй харьцуулан, үнэлгээг бодитой, бүрэн зөв хийсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг оновчтой болгох ажлыг хийлээ. Мөн эрсдэлийн шалгуурыг 100 бизнес эрхлэгч, улсын байцаагчдаар хэлэлцүүлж, аймаг, нийслэлийн улсын байцаагчдын саналыг авч тусган сайжруулсан.</p> <p>✓ МХЕГ-ын даргын зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг системийн хэмжээнд зохион байгуулж эрсдэлийн ангилалд хамааруулах объектын жагсаалтыг Шадар сайдын “Жагсаалт батлах тухай” 2018 оны 11-р сарын 30-ны өдрийн 116 дугаар тушаалаар батлууллаа. Мэргэжлийн хяналтын системийн 33 нэгжийн нийт 1458 удирдлага, улсын байцаагчийн 70624 шалгуулагч этгээдийн хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 140519 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. Нийт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдэл их 21326 /15.1%/ объект, эрсдэл дунд 80869 /57,7%/ объект үнэлэгдсэн. Харин эрсдэл бага 38324 /27,2%/ объект үнэлэгдсэн байна. Эрсдэл их үнэлэгдсэн объектын тоог 2017 оныхтой харьцуулж үзэхэд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, эрсдэл 3677 объектод өссөн байна. Их болон бага эрсдэлтэй үнэлэгдсэн объектын эзлэх хувийн өөрчлөлтийг үзвэл, өмнөх оныхоос эрсдэл ихтэй объектын эзлэх хувь 0,8%-иар өссөн, эрсдэл багатай объектын эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад 0.2%-иар буурсан байна.</p> <p>✓ Импортын барааны эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг оновчлох зорилгоор АХБ-ны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл”-ийн олон улсын зөвлөхүүдтэй хамтран ЗГ-ын 2014 оны 233-р тогтоолоор баталсан эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийг олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, 2019 оны 6 дугаар сард багтаан Шадар сайдын ажлын албанд хүргүүлэх шийдвэрийн дагуу ажиллаж байна.</p> <p><b><u>Хяналт шалгалтын үйл ажиллагааг ил тод болгох зорилгоор:</u></b></p> <p>✓ Аж ахуйн нэгж, байгууллагууд хяналт шалгалттай холбоотой өөрийн байгууллагын мэдээллийг <a href="http://shilenkhyanalt.gov.mn">shilenkhyanalt.gov.mn</a> вэбсайтын порталаар дамжуулан 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүлээн авах боломжийг бүрдүүллээ. Аж ахуйн нэгж байгууллага тус</p>
--	--	--	--	---

				<p>порталд нэвтэрснээр Мэргэжлийн хяналтын байгууллагаас төлөвлөсөн хяналт шалгалтын хугацаа, удирдамжийг цахимаар хүлээж авахаас гадна сүүлийн 3 жилийн эрсдэлийн шалгуурын болон хяналтын хуудасны үнэлгээ, лабораторийн сорилтын дүн, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, улсын байцаагчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хүлээн авах боломжтой. Мөн мэргэжлийн хяналт шалгалттай холбоотой санал, гомдол байвал тус порталаар дамжуулан Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн байгууллагын даргад цахимаар ирүүлэх боломжийг бүрдүүлсэн. ААНБ-д тус порталыг ашиглах тухай МХЕГ-ын даргын 2018 оны 01/1139 дугаар албан бичгийг боловсруулж, олон нийтэд хүргэлээ.</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Шилэн хяналтын цахим системийн “Тайлан”-ийн модулийг боловсронгуй болгох 11 сая төгрөгийн санхүүжилтээр Интерактив ХХК-тай гэрээ байгуулж, 1.8 сая төгрөгөөр МХБ-ын 40 удирдах ажилтанд тоон гарын үсгийн төхөөрөмж авч, удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулах, тайлангийн модулийг сайжруулах ажлууд хийж байна. 2018.03.29-ний өдөр Мэргэжлийн хяналтын системийн нийт ажилтнуудад Интерактив ХХК-тай хамтран онлайн сургалтыг зохион байгуулж, цахим системийн хяналт шалгалтын сайжруулсан модулийг ашиглалтад оруулснаас гадна шалгалтын удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг боллоо.</li><li>✓ МХЕГ-ын даргын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн сангийн маягт батлах тухай” А/92 дугаар тушаалаар 92 төрлийн маягтыг баталж, хяналт шалгалтын статистик мэдээг стандарт загварт орууллаа. Цахимд бүртгэсэн мэдээлэлд дүн шинжигээ хийж, улсын байцаагчийн хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, түүнд авсан арга хэмжээний оновчтой байдал, барагдуулалтад хяналт тавьдаг болсон.</li><li>✓ Цахим мэдээллийн сангийн мэдээллийг холбогдох төрийн төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдэд батлагдсан маягтын дагуу статистик мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүллээ. Холбогдох яам, агентлагуудтай уулзалт, хэлэлцүүлгээр нийтлэг зөрчил, тулгамдсан асуудлыг танилцуулан зохицуулалтыг сайжруулах талаар хамтран ажиллаж, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгууллаа.</li><li>✓ АХБ-ны санхүүжилттэй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор “Бизнесийн процессын шинжилгээ”-г гадаад зөвлөхөөр гүйцэтгүүлж, эцсийн тайланг хүлээн авч 8 удаагийн уулзалт, сургалтаар хэлэлцлээ. Цаашид худалдааг хөнгөвчлөх ажлыг холбогдох</li></ul>
--	--	--	--	---

					<p>байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, боловсронгуй болгосон хилийн хяналт шалгалтын процессийг цахимжуулах цахим системийн ToBe загварыг гаргах ажил олон улсын зөвлөлтэй хийгдэж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Интерпрайз архитектурин олон улсын зөвлөлтэй хилийн хяналтын удирдлагын систем, програм хангамж боловсруулах, холбогдох тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах ажлыг гүйцэтгүүлэхээр төлөвлөн мөн зөвлөхийн гарааны болон дунд шатны тайланг хүлээн авсан.</li> <li>2. Хилийн хорио цээрийн байгууламж, лабораторийн үйл ажиллагаа, цахим ситемийг судлан хилийн цахим системийн ToBe загварт тусгах зорилгоор туршлага судлах аяллыг АНУ, Англи, БНСУ-ын хилийн хорио цээрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүллээ.</li> <li>3. Дэлхийн банк, ОУСК, АХБ-ны хамтран “Худалдааг хөнгөвчлөх төсөл”-ийн хүрээнд хил дээрх мэргэжлийн хяналт болон гаалийн хяналт шалгалтын өнөөгийн байдлыг тодорхойлох уулзалт, гүний терминалтай танилцах үйл ажиллагаа, бусад улс орны сайн туршлагыг судлах олон улсын 3 сургалтыг Английн Лондон хотод болон үндэсний хэмжээнд зохион байгууллаа.</li> <li>4. Геологи, уул уурхайн хяналт шалгалтын <a href="http://gmiis.inspection.gov.mn">gmiis.inspection.gov.mn</a> цахим системийг Шилэн хяналтын цахим системтэй холбож ашиглалтад орууллаа. Монгол Германы хамтын ажиллагааны төслийн 50 сая төгрөгийн санхүүжилтээр Интерактив ХХК, Дайверс ХХК-тай хамтран холбох ажлыг хэрэгжүүлж 7-р сарын 4-ний өдөр хүлээж авлаа. Ингэснээр уурхай дээр GAFMAP программ, GIIMS цахим системийг ашиглан зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянах, мөн интернетгүй орчинд цахим системтэй ажиллах нөхцөлийг бүрдүүллээ.</li> </ol>
2	Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх	2018-2020	ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ	<p>✓ Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх чиглэлээр 2018-2020 онд хийгдэх төлөвлөгөөний энэхүү заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр ЗГХЭГ, СХЗГ, ТӨБЗГ-аас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна. Гэвч МХЕГ нь дотоод хяналтыг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой алхмуудыг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 10 дугаар зорилго, Эрсдэлийн удирдлагын стратегийн 2.1.2 заалтын хүрээнд хэрэглэгч, бизнес эрхлэгчид хуулийг сайн дураар сахин биелүүлэх соёлыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах 10 байгууллагыг сонгосон.</li> <li>2. МХЕГ-аас түшиц 10 байгууллага, аймаг, нийслэлийн МХГ бүр 1-2 байгууллагыг сонгон, санамж бичгийн хүрээнд дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, хамтран ажиллан, бусад 10 бизнесийн байгууллагад туршлага хуваалцах арга хэмжээг зохион</li> </ol>	

				байгуулахаар 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.1-т тусган Шадар сайдаар батлууллаа.
3	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2018-2022	ЗГХЭГ, МХЕГ	<p>✓ Зөвхөн шалгалтын хэлбэрийг ашиглаж, улсын байцаагчид торгох, хаах албадлагын аргыг хэрэглэдэг байсан. Энэ нь бизнес эрхлэгчдээс зөрчлөө арилгах биш, торгууль нөхөн төлбөр тавиулахгүй байх, хаалгахгүй байхын тулд танил тал хайдаг. Энэ нь улсын байцаагчдыг авлигад өртүүлэх нэг нөхцөл болдог байсан.</p> <p>✓ Шалгалтаас гадна “Зөвлөн туслах үйлчилгээ”, “Салбарын сургалт”, “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт”, “Баталгаажуулах үйл ажиллагаа”, “Тандалт судалгаа”, “Хяналт шинжилгээ” гэсэн 6 хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх замаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр журам, заавруудыг боловсруулан мөрдөж байна. Тус журам, заавраар улсын байцаагч зөвхөн зөрчил илрүүлээд торгох, хаах биш илэрсэн зөрчил, шаардлага хангаагүй асуудлаар судалдаг, зөвлөгөө өгдөг байх зохицуулалтыг бий болгосон. Ингэснээр бизнесүүд манай байгууллагад хүсэлт гаргаж зөвлөгөө авах эрмэлзэлтэй боллоо.</p> <p>✓ Урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн хяналт шалгалтаас гадна аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналт хамтын хяналтын хэлбэрийг нэвтрүүлж эхэлсэн. Аюул эрсдэл, хордлого, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүргийг зөвхөн улсын байцаагчийн үүрэг, хариуцлага гэж ойлгож, бизнес эрхлэгчид улсын байцаагчийг аргалахад л болно гэсэн сэтгэгдлийг бий болгож байсан. Энэ нь бизнесүүд хяналтын байгууллага, улсын байцаагчийг хяналт шалгалтаар ирэх үед л бэлтгэлээ хангаж бусад үед хяналтгүй байсантай холбоотой. Иймд Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегитай болсон. Энэ стратегитай болсноор зөвхөн улсын байцаагч бизнес эрхлэгч дээр очиж эрсдэл, аюулыг бууруулах биш аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгосон. Хэрэглэгч, үйлчлүүлэгч өдөр тутам бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа байнгын хяналт тавьж, шаардлага хангасан эсэхийг хянах 15 ХЭРЭГЛЭГЧИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС-ыг бий болгосон. Ингэснээр хэрэглэгч, үйлчлүүлэгчид аюулгүй бөгөөд чанартай эсэхийг хянах мэдлэг, чадвартай болж, тодорхой эрсдэлийг хуваалцаж, бизнес дээр улсын байцаагчийн адил хяналт тавьдаг болно. Ингэснээр улсын байцаагч төдийгүй хэрэглэгч бүрийн хяналтан дор аюулгүй байдлаа хангаж ашиг орлоготой ажиллахад нөлөөлж байна. Хэрэглэгч нь худалдан авч буй бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс үүсч болох аливаа эрсдэлийг тооцон сонголтоо зөв хийж чадаж байгаа эсэхэд тандалт судалгаа хийх 2018 оны 11-р сарын 17-ны өдрийн 01/269 удирдамжийг МХЕГ-ын даргаар батлуулан</p>

					<p>Өвөрхангай аймаг, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт судалгааны ажлыг эхлүүлээ. Тус судалгааны ажлын үр дүнд хэрэглэгч аюулгүй, чанартай бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авахад анхаарах асуудлын жагсаалтыг гаргаж, олон нийтэд мэдээлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.</p> <p>✓ МХБ-аас 2019 онд баримтлах бодлогыг Хяналтын газруудтай хамтран тодорхойлж, 2019 оны хяналт шалгалтын төлөвлөлтийг Хяналтын газар тус бүрээр боловсруулах, уялдуулах ажлыг арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа. МХЕГ-ын даргын “Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөлт хийх аргачлал” батлах тухай 2018 оны 11-р сарын 27-ны өдрийн А/172 дугаар тушаалыг батлуулан аймаг, нийслэлийн МХГ-уудыг төлөвлөлт хийх арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан 140519 объектоос их, дунд үнэлэгдсэн хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 10100 объектыг төлөвлөгөөт шалгалт, 5613 объектыг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулахаар төлөвлөлөө. Мөн 2019 онд бусад хяналтын 5 хэлбэрээр 178 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж МХЕГ-ын даргын 2018 оны 11-р сарын 30-ны өдрийн А/175 дугаар тушаалаар батлан олон нийтэд хуулийн хугацаанд зарлалаа.</p>
<b>Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>					
4.1.6.2. хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн заагийг тодорхойлох	4	Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	2017-2019	АТГ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ	<ul style="list-style-type: none"> <li>• 2018 онд 10 төрийн байгууллага, 12 төрийн бус байгууллага мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах санамж бичиг, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.</li> <li>• Төрөөс бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хяналт шалгалтын давхардал, хүнд суртлыг арилгах зорилгоор хамтран хяналт шалгалт хийх саналыг төрийн захиргааны байгууллагуудаас авч хяналт шалгалт, аттестатчиллыг хамтран хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирч, хяналт шалгалтын давхардлыг арилгах, бизнес эрхлэгчдэд учрах хүндрэл бэрхшээлийг арилгах ажилд ахиц гарсан.</li> <li>• Холбогдох хууль, тогтоомжоор олгогдсон чиг үүргийн дагуу дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж буй 557 аж ахуйн нэгж, байгууллагад 24 сэдвээр, бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд хууль эрх зүй, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болгох зорилгоор бусад салбарын сургалтыг 39 сэдвийн хүрээнд зохион байгуулж, 6438 аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтнуудыг хамрууллаа.</li> </ul>

				<p>Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах чиглэлээр <u>зохион байгуулсан сургалтуудаас онцловол:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх сүлжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад хүлэмж, газар тариалан эрхлэгчид болон ургамал хамгааллын бодис, бордоо импортлогч, ханган борлуулагч 80 гаруй аж ахуйн нэгж, иргэд оролцож, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх сүлжээнд хүнсний аюулгүй байдлыг хангахад мөрдөгдөх хууль, эрх зүйн орчин, тавигдах шаардлага, Монгол улс дахь химийн бодис, биобэлдмэлийн өнөөгийн байдал, эрүүл мэнд, удмын санд нөлөөлөх эрсдэл, ургамлын гарал үүслийн гэрчилгээ олгох журмын талаар мэдээлэл, мэдлэг олгож, хэлэлцүүлэг өрнүүллээ.</li> <li>• “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгололт, хадгалалтад тавигдах шаардлага” сэдэвт сургалтыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 85 ААН-ийн төлөөллийг оролцуулан зохион байгуулав. Сургалтаар хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648-2016 стандартын дагуу хүнсний бүтээгдэхүүний шошгод тусгах мэдээлэл ямар байх, органик хүнсний шошгын мэдээлэлийг хэрхэн авах, хаяг шошгын мэдээллийг буруу бичигдсэнээс үүсэх зөрчлийн талаар мэдээлэл өгөв.</li> <li>• “Хөшигийн хөндийд баригдаж буй Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын цацрагийн аюулгүй байдал, барилга байгууламж, зам талбайн ашиглалт, арчлалтын талаар сургалт зохион байгуулах” сэдэвт сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулав. Сургалтанд захиалагч, зохиогч, гүйцэтгэгч 25 аж ахуйн нэгж байгууллагын 42 инженер техникийн ажилтан хамрагдсан. Мөн Хөшигийн хөндий-Улаанбаатар чиглэлийн 32,227 км хурдны авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажилд анхаарах асуудлаар сургалт зохион байгуулж, улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг өгч ажилласан.</li> <li>• “Хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй зураг төсөл зохиогч, захиалагч аж ахуйн нэгж байгууллагуудад салбарын сургалт зохион байгуулах” сэдэвт сургалтын хөтөлбөрийн дагуу Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвтэй хамтран хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй зураг төсөл зохиогч, захиалагч аж ахуйн нэгж байгууллагуудад салбарын сургалт зохион байгуулав. Сургалтанд захиалагч, зохиогч, гүйцэтгэгч 36 аж ахуйн нэгж байгууллагын 57 инженер техникийн ажилтан хамрагдсан.</li> <li>• “Эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, нэвтрүүлэх нь” сэдэвт салбарын сургалтад хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа</li> </ul>
--	--	--	--	---



				<p>явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын 4600 албан тушаалтан, тогооч, менежер зэрэг албан тушаалтныг хамруулан 17 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Сургалтаар “Хоолны газрын эрүүл ахуйн зохистой дадал”, “Хоол үйлдвэрлэлийн газарт тавигдах шаардлага”, “Ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн горим”, “Хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх” нь сэдэвт хичээл зааж, гарын авлага, зөвлөмж тарааж ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"><li>• Эмийн сангууд салбарын хууль тогтоомж, бүтэц үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэх, эм зүйч, эм найруулагчид мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, гарч болзошгүй эрсдэл, сөрөг үр дагаврын талаарх мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлж тэдгээрээс урьдчилан сэргийлэх, зохистой дадлын шаардлагыг хангуулж зах зээл дэх эмийн чанар аюулгүй байдлыг бий болгох зорилгоор эмийн сангийн салбарын сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийслэлийн 9 дүүргийн 345 эмийн сангийн 415 мэргэжилтнүүдийг хамрагдлаа. Энэхүү сургалтанд оролцсон эм зүйн мэргэжилтнүүд өдөр тутмын үйл ажиллагаандаа эм зүйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллахаа амлахын зэрэгцээ жороор олгох эмийг зөвхөн эмчийн бичсэн жорын дагуу олгохыг мэргэжил нэгт нөхөддөө уриалж гарын үсэг зурцгаалаа.</li><li>• “Эрүүл мэндийн салбарын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны соёл” сэдэвт сургалтыг Эрүүл ахуй, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын нийгэмлэгтэй хамтран 2018 оны 03 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд Нийслэл хотод Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эмнэлгийн салбарын удирдлага, цацрагийн аюулгүй байдал хариуцсан ажилтан, рентген техникч нарт зориулсан зохион байгууллаа. Тус сургалтад 55 байгууллагын 62 албан хаагчид оролцсон.</li><li>• Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хууль, дүрмийг сурталчилах сургалтын хүрээнд УУХҮЯ, АМГТГ, Монголын Үйлдвэрлэлийн геологчдийн холбоотой хамтран “Монголын геологи хайгуул-2018” чуулга уулзалтыг 2018 оны 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Чуулга уулзалтаар “Геологи, эрдэс баялгийн салбарын төрийн бодлого”, “Геологи, хайгуулын ажлын хэрэгжилт ба орон нутагт” сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг, “Региональ геологийн судалгаа”, “Хайгуулын ажлын аргачлал, үр дүн”, “Геологи, ашигт малтмалын судалгаа” сэдвүүдийн хүрээнд хурал, ханын илтгэл, үзэсгэлэн, мэргэшүүлэх сургалт тус тус зохион байгуулагдсан ба чуулга уулзалтаас гарсан үр дүнгээр зөвлөмж гарган, холбогдох газруудад хүргүүлсэн.</li></ul> <p>Эхний хагас жилд нийгэмд тулгамдсан тодорхой асуудлаар</p>
--	--	--	--	---

				<p><u>хэрэглэгчдэд чиглэсэн 3 сарын аяныг зохион байгуулсан бөгөөд энэхүү сарын аяны хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулсан:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2018 оны 01 сарын 15-наас 02 сарын 15-ны хооронд “Хуулиа мөрдье-21” сарын аяныг Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газраас хариуцан аймаг, нийслэлийн, дүүргийн Цагдаагийн газар, хэлтэс, Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн төвтэй хамтарч сарын аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд 282 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулж, 2819 аж ахуйн нэгж, 36038 иргэнийг хамруулж, 101 төрлийн 24796 гарын авлага, зөвлөмжийг тарааж 354 мэдээллийг вэб сайтад байршуулж, 150 удаа телевиз нэвтрүүлэгт оролцож, 54 удаа радио, сонинд мэдээлэл өгсөн байна.</li> <li>• 2018 оны 04 сарын 02-ноос 30-ны хооронд “Зохистой хөдөлмөр-2018” сарын аяныг Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газраас хариуцан зохион байгуулсан. “Нийгмийн сайн сайхны төлөө-Хөдөлмөрийн хяналт” уриан дор зохион байгуулсан уг сарын аяны арга хэмжээнд ХНХЯ-ны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, МАОЭНХ, МҮЭХ, ОУХБ, Японы Засгийн Газрын JiCA төсөл, Европын холбооны SECiM төсөл, ХБНГУ-ын Фрейдрих Эбертийн сантай хамтран ажиллалаа. Аж ахуй нэгж байгууллага, иргэдэд осол аваараас урьдчилан сэргийлэх, ажилчдын эрүүл мэндийн хамгаалах, аюулгүй байдал хангуулах, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд улсын хэмжээнд салбарын болон байгууллагын 126 удаагийн сургалтад 370 ААНБ-ын 7437 ажилтан албан хаагч, МСҮТ-ийн сурагчид, 4 нөхөрлөлийн 20 гишүүдийг хамрагдсан.</li> <li>• 2018 оны 05 дугаар сарын 01-нээс 31-ны хооронд “Эрүүл мал – Эрсдэлгүй бүтээгдэхүүн” сарын аяныг Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын газраас хариуцан зохион байгууллаа. Аяны хүрээнд 268 сургалт зохион байгуулж, 99071 хүнийг хамруулсан байна. 245 төрлийн 70069 ширхэг гарын авлага, 240 төрлийн 38036 ширхэг зөвлөмжийг аж ахуй нэгж, иргэд, малчдад тарааж ажилласан байна.</li> </ul>
Төлөвлөгөөнд тусгагдсан бусад үйл ажиллагаа	Ажилтнуудыг хариуцлагажуулах чиглэлээр	2017-2019	МХЕГ	<p>1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны 167 дугаар тушаалаар “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээний загвар”-ыг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/173 дугаар тушаалаар “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгааны маягт”-ыг батлан төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа” гаргаж, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ” байгуулж ажилласнаар санаатай үйлдэл гаргаснаас бусад тохиолдолд Мэргэжлийн хяналтын удирдах албан тушаалтан, улсын байцаагч ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргахаас 100 хувь</p>

				<p>хамгаалагдах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>2. Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, Хилийн мэргэжлийн хяналтын албадын дарга нарын түр эзгүй байх хугацаанд албан үүргийг нь орлон гүйцэтгэх албан тушаалтны жагсаалтыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/185 дугаар тушаалаар батлан мөрдүүлсэн. Ингэснээр орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын албан ажлын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдснаас гадна удирдлагын зүгээс албан үүргээ хэн дуртай албан тушаалтанд хариуцуулдаг, орон нутагт ямар албан тушаалтан байгууллагын даргыг орлож байгаа, тэдгээрээр орлон гүйцэтгүүлэх албан ёсны шийдвэр гаргасан эсэх, төсвийн шууд захирагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхэд халдсан эсэх, урамшуулал авсан эсэх зэрэг тодорхойгүй нөхцөл байдал үүсдэг үндсэн шалтгаан арилж, орлон гүйцэтгэх ажиллагаанд нэг стандарт тогтсон гэж үзэж байна.</p> <p>3. Төрийн албаны залгамж холбоог сайжруулах, ажил олгогч, ажилтны хариуцлагыг дээшлүүлэх үүднээс Мэргэжлийн хяналтын албан хаагчийн ажил хүлээлцэхэд хүлээн авах баримт, материалын жагсаалтыг МХЕГ-ын даргын 2017 оны А/202 дугаар тушаалаар батлан мөрдүүллээ. Энэхүү тушаалыг батлан мөрдүүлснээр нөгөө талаар төрөөс цалин авч, олон жил хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээ, судалгаа, файлаа устгах замаар ажил хүлээн авч байгаа ажилтныг мэдээлэлгүй үлдээх, улмаар тухайн албан тушаалын залгамж холбоо тасрах, төрийн өмч хөрөнгийг хүлээлгэн өгөхгүй зугатаах эрсдэлийг таслан зогсоосон.</p> <p>4. “Нууцын баталгааны батламж”-ийн загвар боловсруулж, төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтнуудтай байгуулан, хяналт тавьж ажиллалаа. Нууцын батламжид гарын үсэг зурж, баталгаа гаргуулснаар мэргэжлийн хяналтын албан хаагчийн зүгээс албан үүргийн шугамаар олж мэдсэн хувь хүн, хуулийн этгээдийн нууцыг чанд хадгалах, баталгаагүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх, гэмт хэргийн шинжтэй мэдээллийг холбогдох байгууллагад шилжүүлэх, ёс зүйн дүрэмд захирагдан ажиллах үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх эрх зүйн орчин бий болсон.</p> <p>5. Нэгж, албан тушаалын чиг үүргийг нарийвчлан тогтоолоо. Энэхүү ажлын хүрээнд байгууллагын нэгж, албан тушаалтнуудын чиг үүргүүдийг Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолд заасан чиг үүрэгтэй уялдуулах, газар, хэлтэст хүргүүлж санал авах, ажлын байрны тодорхойлолтыг агуулгыг 80 хувь шинэчлүүлэх замаар 33 нэгжийн чиг үүрэг, 145 ажилтны албан тушаалын тодорхойлолтыг МХЕГ-аас батлан</p>
--	--	--	--	--

					<p>мөрдүүлсэн. Мөн Нийслэлийн МХГ, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын албадаас санал авч бүтэц, зохион байгуулалт, орон тоог шинэчлэн баталснаар төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулсан.</p> <p>6. Чиг үүргийн давхардлыг арилгав. МХЕГ-ын нэгжүүдийн чиг үүргийн давхардлыг арилгах хүрээнд тус газрын Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газарт харъяалагдаж байсан гамшгийн асуудал хариуцсан Дотоод ажил хариуцсан мэргэжилтний чиг үүрэг, орон тоог ажиллах хүчний хамт Дэд бүтцийн хяналтын газарт, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газарт харъяалагдаж байсан эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчийн чиг үүрэг, орон тоог ажиллах хүчний хамт Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газарт тус тус шилжүүлэх зохицуулалтыг хийв.</p>
Төлөвлөгөөнд тусгагдсан бусад үйл ажиллагаа		Хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан	2017-2019	МХЕГ	<p>1. Төсвийн шууд захирагч нарыг Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-д зааснаар нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнгээр, нэгжийн менежерүүдийг удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дүгнэлт гаргуулан томилж хэвшсэн. Төрийн албаны зөвлөлтэй хамтран сонгон шалгаруулалтын төстийн шалгалтыг цахим хэлбэрээр авч сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг гадны нөлөөллөөс ангид болгосон.</p> <p>2. Нийтийн албанд нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар 100 хувь хянуулж, дүгнэлтэд үндэслэн томилгоо хийж хэвшсэн.</p> <p>3. Сургалтын шинэ арга хэлбэрийг нэвтрүүлж, ажлын байран дээр тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлсэн. Мэргэжлийн хяналтын байгууллагаас санаачлан зохион байгуулдаг гол сургалт нь шинээр ажилд орсон улсын байцаагч нарыг бүрэн хамруулдаг “Шинэ байцаагч” модульт сургалт юм. Энэхүү сургалт нь төрийн албанд анх орж ирж байгаа ажилтнуудад төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, цалин хөлс зэрэг төрийн албан хаагч, улсын байцаагчийн мэдвэл зохих мэдлэгийг нэг дороос олгож, шаардлагатай гарын авлагын багцыг гардуулдагаараа онцлогтой. Түүнчлэн шинэ мэдлэг, мэдээлэл хүргэдэг “Сонсгол мэдээллийн цаг” сургалтыг МХЕГ-т 7 хоног бүрийн лхагва гарагт зохион байгуулж хэвшсэн. Авлигатай тэмцэх газраас 2018 онд зохион байгуулсан багц сургалтуудад МХЕГ-ын 28 албан тушаалтныг хамруулсан.</p>

Төлөвлөгөөнд тусгагдсан бусад үйл ажиллагаа		Авлига, ашиг сонирхлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр	2017-2019	МХЕГ	<p>1. Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газраас олгодог экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Засгийн газрын 12 дугаар байрны 4 давхарт суудаг гэрчилгээ, мэдэгдэл бичих эрх бүхий албан тушаалтнуудыг тус байрны 1 давхарын Зөвлөгөө мэдээллийн төвд шилжүүлэн байршуулсан. Эдгээр албан тушаалтнууд нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Зөвлөгөө мэдээллийн төвд хүлээн авч, нэг цэгээс мэдээлэл өгч, гэрчилгээ, мэдэгдлийг тус төвөөр дамжуулан олгодог болсноор 4 давхарын албан өрөөний үүд сахих үйлчлүүлэгч нарын тоо эрс багасч, тэр хэрээр авлига, ашиг сонирхлын эрсдэл буурсан гэж үзэж байна.</p> <p>2. Экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл олгох хугацааг богиносгож, үйлчлүүлэгч нарыг чирэгдүүлэх үндсэн нөхцөлийг арилгасан.</p> <p>3. Экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл олгохтой холбогдсон цогц мэдээлэл бүхий мэдээллийг самбарыг Зөвлөгөө мэдээллийн үүдэнд байршуулж, иргэдийг холбогдох мэдээ, мэдээллээр хангасан.</p> <p>4. Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгодог зөвшөөрөл, дүгнэлт, гэрчилгээ, мэдэгдлийн талаарх мэдээллийг бүрэн агуулсан баримт бичгийг байгууллагын вэб сайтаар дамжуулан мэдээллэсэн.</p> <p>5. Мэргэжлийн хяналтын байгууллага, хяналт шалгалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахимжуулах ажлыг үе шаттайгаар нэвтрүүлж байна.</p> <p>6. Ажилтнуудыг хариуцлагажуулах, соён гэгээрүүлэх, ёс зүйг сахиулах ажлыг шат дараатай авч хэрэгжүүлж байна.</p>
---	--	--	-----------	------	---

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР